

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/133/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

---

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт .....	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/171  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.ДОРЖ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ  
D 2022/2021 01/171  
**19020531**

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,562,996.31</b>	<b>31,426,655.45</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,562,996.31	31,426,655.45
351	<b>Түүхий эд материал</b>	3,780,355.40	3,780,355.40
35110	Тусгай зориулалттай материал	3,780,355.40	3,780,355.40
354	<b>Хангамжийн материал</b>	24,782,640.91	27,646,300.05
35410	Бичиг хэргийн материал	708,350.00	770,350.00
35420	Аж ахуйн материал	23,739,770.91	24,486,258.05
35460	Хүнсний материал	334,520.00	2,389,692.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,601,815,082.90</b>	<b>1,581,781,682.57</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,601,815,082.90	1,581,781,682.57
392	<b>Биет хөрөнгө</b>	1,549,805,082.90	1,529,771,682.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,554,501,016.00	1,554,501,016.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-112,752,118.81	-173,024,302.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,792,502.03	134,675,895.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-100,350,090.39	-56,544,904.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,793,117.58	72,788,206.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,968,349.79	-25,717,292.39
39209	Зам, гүүрний байгууламж	6,000,000.00	6,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-600,000.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	800,000.00	800,000.00
39217	Ном	14,989,006.28	16,893,062.96
393	<b>Биет бус хөрөнгө</b>	52,010,000.00	52,010,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	52,010,000.00	52,010,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,630,378,079.21</b>	<b>1,613,208,338.02</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,630,378,079.21</b>	<b>1,613,208,338.02</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,630,378,079.21	1,613,208,338.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	449,177,766.52	449,177,766.52
51101	Өмч: - төрийн	449,177,766.52	449,177,766.52
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	426,115,618.04	410,013,447.02
51210	Өмнөх үеийн үр дүн	426,115,618.04	427,183,188.21
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-17,169,741.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	755,084,694.65	754,017,124.48
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,630,378,079.21</b>	<b>1,613,208,338.02</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>777,248,546.82</b>	<b>817,462,883.82</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>19,599,516.82</b>	<b>73,023,754.82</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	19,599,516.82	73,023,754.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,127,660.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,127,660.00	175,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>138,235,430.00</b>	<b>192,908,829.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	619,413,600.00	551,530,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	56,970,000.00	13,594,829.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,970,000.00	13,594,829.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,265,430.00	179,314,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,265,430.00	179,314,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>846,713,783.07</b>	<b>834,448,625.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>846,713,783.07</b>	<b>834,448,625.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	703,864,023.18	792,913,408.03
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	458,254,586.96	444,334,995.65
210101	Үндсэн цалин	458,254,586.96	307,926,631.95
210102	Нэмэгдэл	00.00	93,355,971.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	12,905,354.34
210104	Урамшуулал	00.00	30,147,038.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,329,605.15	57,843,746.37
210201	Тэтгэврийн даатгал	40,532,913.82	40,481,266.83
210202	Тэтгэмжийн даатгал	4,534,231.50	4,440,704.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,627,385.00	3,552,563.07
210204	Ажилгүйдлийн даатгал	875,244.47	870,230.12
210205	Эрүүл мэндийн даатгал	8,759,830.36	8,498,982.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	85,279,947.06	177,732,171.00
210301	Гэрэл, цахилгаан	13,492,374.00	6,164,915.00
210302	Түлш, халаалт	71,675,573.06	171,414,256.00
210303	Цэвэр, бохир ус	112,000.00	153,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,918,070.41	6,402,589.00
210401	Бичиг хэрэг	368,140.00	956,579.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,090.00	777,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,000.00	125,000.00
210404	Ном, хэвлэл	21,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	41,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,509,610.00	4,543,410.00
210408	Бараа материал акталсны зардал	2,588,230.41	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,216,858.00	11,284,368.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	372,870.00	499,990.00
210502	Хоол, хүнс	11,795,288.00	9,654,078.00

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,048,700.00	1,130,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,300.00	910,000.00
210604	Урсгал засвар	23,300.00	910,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	403,100.00	253,100.00
210702	Дотоод албан томилолт	403,100.00	253,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	617,100.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	617,100.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	79,821,455.60	94,152,438.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	844,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,495,300.00	667,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,326,155.60	92,640,588.01
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	142,849,759.89	41,535,216.98
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	78,974,025.89	20,520,026.98
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	78,974,025.89	20,520,026.98
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	63,875,734.00	21,015,190.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,987,564.00	10,938,390.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,498,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,471,900.00	9,156,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	918,170.00	920,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-69,465,236.25</b>	<b>-16,985,741.19</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	5,559,744.00	184,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,559,744.00	184,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-5,559,744.00	-184,000.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-75,024,980.25</b>	<b>-17,169,741.19</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	449,177,766.52	755,370,612.70	500,854,680.24	1,705,403,059.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	285,918.05	285,918.05
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>449,177,766.52</b>	<b>755,370,612.70</b>	<b>501,140,598.29</b>	1,705,688,977.51
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-75,024,980.25	-75,024,980.25
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>449,177,766.52</b>	<b>755,084,694.65</b>	<b>426,115,618.04</b>	<b>1,630,378,079.21</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>449,177,766.52</b>	<b>755,084,694.65</b>	<b>426,115,618.04</b>	<b>1,630,378,079.21</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,067,570.17	1,067,570.17
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>449,177,766.52</b>	<b>755,084,694.65</b>	<b>427,183,188.21</b>	<b>1,631,445,649.38</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,067,570.17	00.00	-1,067,570.17
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,169,741.19	-17,169,741.19
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>449,177,766.52</b>	<b>754,017,124.48</b>	<b>410,013,447.02</b>	<b>1,613,208,338.02</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>758,776,690.00</u></b>	<b><u>744,614,129.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,127,660.00</b>	<b>175,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,127,660.00	175,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,127,660.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,127,660.00	175,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>757,649,030.00</b>	<b>744,439,129.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	619,413,600.00	551,530,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	56,970,000.00	13,594,829.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,970,000.00	13,594,829.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,265,430.00	179,314,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,265,430.00	179,314,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>758,776,690.00</u></b>	<b><u>744,614,129.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>758,776,690.00</b>	<b>744,614,129.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>617,948,894.11</b>	<b>702,791,712.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	458,254,586.96	444,334,995.65
210101	Үндсэн цалин	341,673,850.47	307,926,631.95
210102	Нэмэгдэл	72,678,245.44	93,355,971.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,922,684.00	12,905,354.34
210104	Урамшуулал	29,979,807.05	30,147,038.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,329,605.15	57,843,746.37
210201	Тэтгэврийн даатгал	44,014,933.24	40,481,266.83
210202	Тэтгэмжийн даатгал	3,641,701.91	4,440,704.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,925,500.00	3,552,563.07
210204	Ажилгүйдлийн даатгал	667,500.00	870,230.12
210205	Эрүүл мэндийн даатгал	7,079,970.00	8,498,982.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	80,265,430.00	177,732,171.00
210301	Гэрэл, цахилгаан	13,492,374.00	6,164,915.00
210302	Түлш, халаалт	66,661,056.00	171,414,256.00
210303	Цэвэр, бохир ус	112,000.00	153,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,509,740.00	3,607,759.00
210401	Бичиг хэрэг	330,000.00	488,129.00
210402	Тээвэр, шатахуун	978,990.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	215,000.00	125,000.00
210404	Ном, хэвлэл	331,850.00	334,630.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	164,600.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,489,300.00	2,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	10,764,872.00	14,722,040.00

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	296,470.00	499,990.00
210502	Хоол, хүнс	9,358,402.00	11,422,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,110,000.00	2,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>176,000.00</b>	<b>223,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	176,000.00	223,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,543,660.00</b>	<b>175,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,543,660.00	175,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,105,000.00</b>	<b>3,153,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,105,000.00	1,753,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>140,827,795.89</b>	<b>41,822,416.98</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>78,974,025.89</b>	<b>20,520,026.98</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	78,974,025.89	20,520,026.98
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,853,770.00</b>	<b>21,302,390.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,965,600.00	11,225,590.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,804,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,165,200.00	9,156,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	918,170.00	920,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	737,139,200.0	704,223,725.1	32,915,474.9	95.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	737,139,200.0	704,223,725.1	32,915,474.9	95.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	723,605,800.0	675,858,008.1	47,747,791.9	93.4
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	450,059,400.0	417,714,420.7	32,344,979.3	92.8
210101	Үндсэн цалин	309,176,400.0	292,991,382.3	16,185,017.7	94.8
210102	Нэмэгдэл	95,480,900.0	86,455,286.2	9,025,613.8	90.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,652,000.0	11,359,354.3	3,292,645.7	77.5
210104	Урамшуулал	30,750,100.0	26,908,397.9	3,841,702.1	87.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,758,000.0	57,843,746.4	2,914,253.6	95.2
210201	Тэтгэврийн даатгал	42,755,700.0	40,481,266.8	2,274,433.2	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,500,600.0	4,440,704.0	59,896.0	98.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,600,500.0	3,552,563.1	47,936.9	98.7
210204	Ажилгүйдлийн даатгал	900,000.0	870,230.1	29,769.9	96.7
210205	Эрүүл мэндийн даатгал	9,001,200.0	8,498,982.3	502,217.7	94.4
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	184,608,900.0	177,732,171.0	6,876,729.0	96.3
210301	Гэрэл, цахилгаан	14,715,000.0	6,164,915.0	8,550,085.0	41.9
210302	Түлш, халаалт	169,693,900.0	171,414,256.0	(1,720,356.0)	101.0
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	153,000.0	47,000.0	76.5
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,845,000.0	3,469,630.0	375,370.0	90.2
210401	Бичиг хэрэг	350,000.0	350,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.0	500,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.0	125,000.0	375,000.0	25.0
210404	Ном, хэвлэл	335,000.0	334,630.0	370.0	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.0	160,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	2,000,000.0	-	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	19,958,500.0	14,722,040.0	5,236,460.0	73.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.0	499,990.0	10.0	100.0
210502	Хоол, хүнс	16,658,500.0	11,422,050.0	5,236,450.0	68.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.0	2,800,000.0	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.0	1,000,000.0	-	100.0

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	223,000.0	223,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	223,000.0	223,000.0	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,153,000.0	3,153,000.0	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.0	1,400,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,753,000.0	1,753,000.0	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,533,400.0	28,365,717.0	(14,832,317.0)	209.6
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,533,400.0	12,145,590.0	1,387,810.0	89.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,612,900.0	11,225,590.0	1,387,310.0	89.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.0	920,000.0	500.0	99.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	737,139,200.0	714,624,173.0	22,515,027.0	96.9
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	551,530,300.0	535,892,002.0	15,638,298.0	97.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	551,530,300.0	535,892,002.0	15,638,298.0	97.2
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	185,608,900.0	178,732,171.0	6,876,729.0	96.3
132001	Орон нутгийн төсвөөс	185,608,900.0	178,732,171.0	6,876,729.0	96.3
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	37.0	36.0	1.0	97.3
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23.0	22.0	1.0	95.7
620003	Үйлчлэх ажилтан	13.0	13.0	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,769,829.00</b>	<b>13,769,829.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,769,829.00</b>	<b>13,769,829.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	313,129.00	313,129.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	138,129.00	138,129.00
210401	Бичиг хэрэг	138,129.00	138,129.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	175,000.00	175,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	175,000.00	175,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,456,700.00	13,456,700.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	4,299,900.00	4,299,900.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,299,900.00	4,299,900.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,156,800.00	9,156,800.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,156,800.00	9,156,800.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	9294929.00	9294929.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,294,929.00	9,294,929.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,294,929.00	9,294,929.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих төлөвших үй явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг эх асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын баг нь 2021 онд 16 ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийн ханган, улирал бүр тайлагнаж ажилласан.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 737,139.2 мянга төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,057.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,292.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

### **Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 737,139.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 730,844.3 мянган төгрөгийн санхүүжилтийг 96.9 хувьтай авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 13,769.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 744,614.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд 50,088.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 20,798.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,904.1 мянган төгрөгийн ном, нийт 72,791.2 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,750.7 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,434.4 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдлээр 68,606.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 493.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 31,478.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 30,423.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

**Авлага, өглөгийн талаар:**

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 31,426.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,581,781.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	28,562.99	31,426.65	2,863.66
Үндсэн хөрөнгө	1,601,815.08	1,581,781.68	(20,033.40)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,630,378.07</b>	<b>1,613,208.33</b>	<b>(17,169.74)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,630,378.07	1,613,208.33	(17,169.74)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,630,378.07</b>	<b>1,613,208.33</b>	<b>(17,169.74)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 31,426.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,863.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,581,781.7 мянган төгрөг болж 20,033.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,613,208.3 мянган төгрөг болж 17,169.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 882,184.8 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 737,139.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр 145,045.6 мянган төгрөгөөр буюу 16.4 хувиар бууруулж баталсан.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 737,139.2 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 714,624.2 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 20,515.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 714,624.2 мянган төгрөг буюу 96.9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 13,944.8 мянган төгрөг төвлөрч, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 9,156.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 313.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,299.9 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгө дансанд 50,088.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 20,798.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,904.1 мянган төгрөгийн ном, нийт 72,791.2 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,750.7 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 2,434.4 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдлээр 68,606.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 98,008.6 мянган төгрөгийн хөрөнгийн дахин үнэлж 68,606.0 мянган төгрөгөөр хөрөнгийн орлогоор бүртгэж тайлагнасан.

### **3.8 Аудитын гол асуудал**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 12 нэр төрлийн 3,947.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй, хүүхдээ асрах чөлөөтэй байгаа албан хаагчийн байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл 264.6 мянган төгрөгийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан, үр дүнгийн урамшуулалт цалин олгохдоо захирлын тушаалаар баталсан хувь хэмжээг багасгаж, дараа сард нэмэгдүүлэх зэргээр өөрчлөн тооцож олгосон байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 176 мэдээллээс 174 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,212.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 4,212.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгөв.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.3 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 12 нэр төрлийн 3,947.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлүүлэх

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа албан хаагчийн байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл 264.6 мянган төгрөгийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, эдийн засгийн ангилал зөрчихгүй байх

#### **3. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1. Илрүүлэлт:**

Үр дүнгийн урамшуулалт цалин олгохдоо захирлын тушаалаар баталсан хувь хэмжээг багасгаж, дараа сард нэмэгдүүлэх зэргээр өөрчлөн тооцож олгож байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Үр дүнгийн урамшуулалт цалинг тушаалаар баталсан хувь хэмжээгээр тооцож олгож байх, ажиллагсадтай холбоотой авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах

#### **4. Шилэн данстай холбоотой асуудал**

##### **4.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд шилэн дансанд 176 мэдээлэл мэдээлэхээс 174 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**4.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянцогт сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4,212.5	-	-	-	-	-	-	4	4,212.5

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)